**ТАНИЛЦУУЛГА**

2021 оны эхний хагас жилд Дэлгэрцогт сумын төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тухай

2021-06-25

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Багийн Засаг дарга болон мэргэжилтнүүдэд хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, **98661922** утсаар, цахимаар болон боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн СӨГ-ыг СӨГ бүртгэх дэвтэрт бүртгэн, холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж, хариуг эзэнд нь утсаар болон албан тоотоор өгч байна.

2021 оны эхний хагас жилд иргэдээс нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж бичгээр нийт 103 өргөдөл, санал, хүсэлт ирүүлснийг 99,8%-ийг хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй 2 өргөдөл байна.

Эдгээр өргөдөл, хүсэлт нь газар эзэмших, өмчлөх, оршин суугаа хаягийн тодорхойлолт, халамж, тэтгэмжид хамрагдах, ажилд орох зэрэг асуудлууд байлаа.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА С.НАРАНТУНГАЛАГ

ЗЕА 0001

Хүснэгт № 1

**2021 оны эхний хагас жилд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэл-тийн /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| 1 | Дэлгэрцогт ЗДТГ | 103 | 101 | | | 2 | 98,5% |
| **Дүн** | | **103** | **101** | | | **2** | **98,5%** |

Хүснэгт № 2

**2021 оны эхний хагас жилд улирлалд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл /хэлбэрээр/**

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар | Биечлэн уулзсан | Бусад |
| 1. | Дэлгэрцогт ЗДТГ | 103 | 21 | 5 | 34 | 43 | |
| **Дүн** | | **103** | **21** | **5** | **34** | **43** | |

Хүснэгт № 3

2021 оны оны эхний хагас жилд нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл /агуулгаар/

| | | |
|---|---|---|
| 1. | Дэлгэрцогт | Нийт өргөдлөөс:<br>Хүсэлт 57<br>Өргөдөл 39<br>Санал 7<br><br>• Ажилд орох 1 буюу 0,09%<br>• Газар өмчлөх,эзэмших,газар өмчлөх эрх шилжүүлэх 38 буюу 36,9%<br>• Оршин суугаа, хүүхдийн мөнгө, хөнгөлөлтүүд 57 буюу 55,3%<br>• Сум өнгө үзэмжийг сайжруулах санал 7 буюу 6,7% |
| | | 2021 оны эхний хагас жилд ирүүлсэн 103 өргөдөл, санал, хүсэлтийн 1 өргөдөл нь ажилд орох, 38 өргөдөл нь газар өмчлөх, эзэмших, эрх шилжүүлэх, 57 хүсэлт нь оршин суугаа хаягийн тодорхойлолт, хүүхдийн мөнгө, өндөр настны хөнгөлөлтүүдэд хамрагдах зэрэг асуудлууд байлаа. 2 өргөдлийн хугацаа болоогүй. |